



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatrural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 02. 09 №

13

Асуулга тавих тухай

Аливаа улс орон холыг харсан хөгжлийн бодлоготой, түүнийгээ хэрэгжүүлэх тодорхой зорилго, зорилтуудтай байж хурдтай хөгждөг жамтай. Монгол төрийн бодлого тодорхой байж тогтвортой хэрэгжих ёстой. Ийм ч учраас манай улс урт хугацааны хөгжлийн бодлогоо тогтмол тодорхойлж, шинэчилж ирсэн.

Хамгийн сүүлд УИХ-д суудал бүхий намуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэг ажиллаж, "Тогтвортой хөгжлийн зорилт-2030" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, 2016 оны УИХ-ын 19 дүгээр тогтоолоор баталсан билээ. Тогтвортой хөгжилд хүрэх түлхүүр нь нийгмийн тэгш бус байдлыг багасгаж, баян хоосны хэт их ялгарлыг бууруулж, ирээдүй хойч үедээ хор хөнөөл учруулахгүйгээр "хэнийг ч ардаа үлдээхгүйгээр" хөгжих явдал юм.

Энэхүү хөгжлийн бодлогодоо нийцүүлэн дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого, зорилтоо тодорхойлох нь улс орны хүн хүч, баялаг, хөрөнгө санхүүгийн нээцийг оновчтой зөв хуваарилах, урт хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг эртнээс судалж бэлтгэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

2016 онд болсон УИХ-ын сонгуульд оролцсон улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө дээрх бичиг баримттай уялдуулан боловсруулж өрсөлдсөн.

Тогтвортой хөгжлийн зорилт батлагдсанаас хойш даруй 3 дахь жилийнхээ нүүрийг үзэж байгаа ч зорилтод тусгагдсан хөгжлийн бодлого, зорилтууд хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээлэл хангалтгүй байгаа тул Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд танд хандан тавьж байна. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан Монгол улсын хөгжлийн үндсэн зорилт болох эдийн засгийг төрөлжүүлж, олон тулгууртай болгох зорилтыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

2. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоо бий болсон эсэх. Тогтвортой хөгжлийн зорилтууд, түүний хэрэгжилтийн явцад аль байгууллага хэрхэн хяналт тавьж ямар дун шинжилгээ хийж байгаа вэ;
3. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр жил бүрийн улс, орон нутгийн төсөвт хүрэлцээтэй тусч байгаа эсэх;
4. Засгийн газраас УИХ-д өргөн барьж хэлэлцүүлж байгаа, хэлэлцэн батлуулсан салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, зорилтууд нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа вэ?
5. Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын 2.2-т заасан "Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах" ажил хийгдсэн эсэх,
6. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолд заасан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд танилцуулж байх заалтын хэрэгжилт,
7. 2020 он гэхэд Тогтвортой хөгжлийн зорилтын нэгдүгээр үе шатанд тавигдсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлж чадах эсэх талаар тодорхой хариултыг боловсруулж ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулахыг танаас хүсье

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН

ГИШҮҮН

Б.БЯМБАЦОГТ

И.АМАРЗАЯА

Б.БАТТӨМӨР

Д.ОЮУНХОРОЛ

Д.ЭРДЭНЭБАТ

